

Улаанбаатар аймгийн захиргаа

1930-11-14-энд Засгийн газрын 38-р тогтоолын 2-р зүйлээр олон аймаг, хот, сумдын дүрмийг шинэчлэн зохиож ирснийг зөвшөөрч улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраар батлуулахаар тогтоожээ.

1931-2-26-энд Засгийн газрын эрхлэх товчооны 10-р хурлын 5-р зүйлээр орон нутгийн захиргааг шинэчлэн өөрчлөх хувьсгалт түр хороодыг түр хороо гэж нэрлэхээр тогтоожээ.

1931 оны 2 дугаар сард нутаг дэвсгэр засаг захиргааны хуваарилалт явуулах “ түр хороод” аймгуудад байгуулагдсан ба мөн 3 дугаар сард сумдад “түр захиргаа” байгуулсан. Мөн 3, 4 дүгээр сард хуучин аймгийн яам, хошуудын тамгын газрын татан буулгаж, шинэ байгуулагдсан сум, аймгийн ардын төлөөлөгчдийн 1 дүгээр их хурал хуралдаж, тариалан зэрэг 13 аймаг байгуулагджээ.

1931-3-29-өд Засгийн газрын эрхлэх товчооны 15-р хурлын 3 дугаар зүйлээр Засаг захиргааны газруудад тамга, тэмдэг гэж давхар олгохыг зогсоож ганц тамга олгох, дөрвөлжин маягийг өөрчлөн дугуй хэлбэртэй болгохоор тогтоожээ.

1931-9-7-энд Засгийн газрын 20-р тогтоолын 4-р зүйлээр Төв аймаг, хотын захиргааг нэгтгэх тухай асуудал боловсруулах комиссыг томилсон байна.

1931-9-21-энд УБХ-ийн тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлын тогтоолоор Төв аймаг Улаанбаатар хотын захиргааны нутаг дэвсгэрийг нэгтгэн Улаанбаатарт төвлөрүүлэх, Улаанбаатар хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг 10 дугаар сарын 1-энд хийх, сонгууль хийсний дараа Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааны нутаг дэвсгэрийг нэгтгэн Улаанбаатарт төвлөрүүлэх, Улаанбаатар хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг 10 дугаар сарын 1-энд хийх, сонгууль хийсний дараа Төв аймаг, Улаанбаатар хотын захиргааг татан буулгасанд тооцох, Улаанбаатар аймгийн захиргааг гишүүд 11, орлогчдыг 5 хүнээр аймгийн захиргааны байгуулалтыг тэргүүлэгч, орлогч, нарийн бичгийн дарга, ерөнхий хэлтэс, цэргийн хэлтэс, хөдөө аж ахуйн хэлтэс, санхүүгийн хэлтэс, хотын нийтийн аж ахуйг эрхлэх хэлтэс, ардыг гэгээрүүлэх явдлын хэлтэс, Цагдан сэргийлэх явдлын хэлтэс, Улсын хянан байцаах бүртгэлийг Эрхлэх товчоо зэрэг зохион байгуулалтаар тогтоожээ.

1931 оны 9 дугаар сарын 21-энд Улаанбаатар хотын тэргүүлэгчид, Засгийн газрын хамтарсан хурлаар, Төв аймаг, Улаанбаатар хотын захиргаа, нутаг дэвсгэрийг нэгтгэн төвлөрүүлж, “Улаанбаатар” хэмээх аймгийн захиргаа байгуулах, сонгуулийг мөн оны 10 дугаар сарын 1-нд хийхээр тогтоожээ.

1931 онд Төв аймаг, хотын захиргаанд явуулсан ажлын тухай илтгэх хуудсанд Улаанбаатар аймгийн захиргааг 1931 оны 10 дугаар сард шинэчлэн нэгтгэж байгуулсан /Хуучин Төв аймагтай/ 1931 оны 3 дугаар сараас хотуудыг өөрчилсөн байна.

1932-8-5 нд Сайд нарын Зөвлөлийн 7-р тогтоолын 11-р зүйлээр Улаанбаатар аймгийн захиргааны зохион байгуулалтыг -3-5 хүнтэй тэргүүлэгчид, Малын ажил ба хадлан тариалангийн хэлтэс, Цэргийн хэлтэс, Санхүүгийн хэлтэс, Ардыг гэгээрүүлэх хэлтэс, Хотын аж ахуйн хэлтэс, Бичиг дансны ангитайгаар баталжээ.

1932-5-27-энд Сайд нарын Зөвлөлийн 9-р тогтоолын 3-р зүйлээр 1931 онд Төв аймаг ба Улаанбаатар хотын захиргааг нэгтгэсэн нь үр дүн өгөөгүй учир салгаж аймаг, хотын захиргаа тус тусад нь байгуулахаар тогтоожээ.

1932 онд Сайд нарын Зөвлөлөөс гаргасан тогтоол /хагас/-д дурдахдаа хүний урьд Сайд нарын Зөвлөлөөс Улаанбаатар хотын захиргааг аж ахуйн талаар биеэ даасан газар болгож ялган байгуулах, тухай гаргасан тогтоолд нэмэгдүүлэн тогтоохдоо, Хотын захиргааг ҮЭ гишүүн, 4 орлогч гишүүнээр байгуулжээ.

Хотын их хурлыг 1932-11 -1-энд хийлгэх-Хотын захиргааны орлого зарлагын төсвийг ялган салгаж 1933 оны 1-р сараас эхлэн явуулах хүртэл хот ба Төв аймаг хоёрын зардлыг нэгтгэсэн төсвөөс гүйцэтгэж байхаар заажээ.

1932 оны 10 сард Улаанбаатар хотын захиргааг Төв аймагтай нэгтгэж Улаанбаатар аймгийн Захиргаа болгосон.

1933 оны Снз дахин шинэ дүрэм баталж УБХ-ын захиргааг СнЗ-д шууд харьяалуулан захирагдах засаг захиргааны нэгж болгосон. тэр жилдээ хотыг 6 хороо болгож хороодын дарга нарт сумын даргын эрх үүргийг гүйцэтгүүлэв.

1933-7-18-нд Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдын 5 дугаар тушаалаар үндсэн хуулиуд зааснаар аливаа тамга тэмдэг дөрвөлжин ба болдоор хийгдсэн байх ёстой атал орон нутгийн яам газруудын тамга дугараг резинээр хийгдсэн нь буруу учир хураан авч үндсэн хуулинд зааснаар шинэчлэн хийлгүүлэхээр заажээ.

1933 оны 12 дугаар сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 42 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл ээр 1930 онд батлагдсан Улаанбаатар хотын захиргааны дүрмийг шинэчлэн баталж, эл дүрэмд хотын захиргаа нь Сайд нарын Зөвлөлийн шууд харьяалалд засаг захиргааны нэгж болохыг заасан бөгөөд бүтцийг нь: Аж ахуйн хэлтэс, Санхүүгийн хэлтэс Паспорт, бичиг эрхлэх хэлтэс, Ардын гэгээрэл боловсролын тасаг, Хотын ариун цэврийн хянан харгалзах газар, Бичиг хэргийн анги, Барьцаалан зээлдүүлэх, Ломбардын газар Галын аюулаас хамгаалах газар, Цагдан сэргийлэх газар, Шүүх, Прокурор зэрэг байна.